



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/30/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан
Утас:261663 Цахим хаяг: Bayrsaikhand@audit.gov.mn
Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг
Утас:323266
Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn
Ахлах аудитор: Ш.Наран
Утас:323266
Цахим хаяг: naransh@audit.gov.mn
Аудитор: Э.Цэлмэгбаяр
Утас:323266
Цахим хаяг: tselmegbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа.....	10
3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
1. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1. Ерөнхий зүйл	15
4.2. Материаллаг байдал	15
4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1. Төлбөрийн акт	17
5.2. Албан шаардлага	17
5.3. Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
- Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний үзүүлэлт
- Хүснэгт 3. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТҮЭМ	Төрийн үйлчилгээ, эрүүл мэнд
УТ	Улс төр
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШСХ	Шүүхийн сахилгын хороо



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ
ДАРГА С.ЭНХТӨР ТАНАА

2026.04.24 № 1131
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийн бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2025 оны 188 дугаар тогтоолын дагуу Улсын дээд шүүхийн балансад бүртгэлтэй 1,390.2 сая төгрөгийн дансны үнэтэй барилга, байгууламж болон 9.8 сая төгрөгийн газрын ашиглах эрхийг балансаас балансад шилжүүлэн авсан. Мөн урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэлтэй байсан 790.1 сая төгрөгийн барилгын сайжруулалтын зардлыг үндсэн хөрөнгийн "Барилга, байгууламж" дансанд капиталжуулж бүртгэсэн байна.

Худалдан авах төлөвлөгөөний дагуу Ланд крузер 300 автомашин 1, Соната маркийн 2 автомашин нийт 300.0 сая төгрөгийн автомашиныг Төрийн худалдан авах ажиллагааны газраар дамжуулан нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэн авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 80.1 сая төгрөг зарцуулсны 62.0 хувийг хуулийн төсөл боловсруулах судалгааны ажлын төлбөр, 14.8 хувийг албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалахтай холбоотой зардал эзэлж байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	874,124.4	139,626.5
33	АВЛАГА	2,864.3	-
34	УРЬДЧИЛГАА	716,693.1	20,868.2
35	БАРАА МАТЕРИАЛ	154,567.0	118,758.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,195,074.9	3,562,848.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,195,074.9	3,562,848.6
39300	Биет хөрөнгө	1,188,333.9	3,549,075.7
39303	Биет бус хөрөнгө	6,741.0	13,772.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,069,199.3	3,702,475.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,650.0	163,597.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,650.0	163,597.1
41300	Өглөг	10,650.0	163,597.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,058,549.3	3,538,878.0
51	Засгийн газрын хувь оролцоо	2,058,549.3	3,538,878.0
51200	Хуримтлагдсан үр дүн	2,058,549.3	3,538,878.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,069,199.3	3,702,475.1

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,864,550.3	6,895,209.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,460.0	6,895,209.3
120	Нийтлэг татварын бус орлого	2,460.0	1,561,094.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,862,090.3	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,746,470.2	5,402,939.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,746,470.2	5,402,939.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,347,483.1	5,328,157.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,910,729.8	3,644,736.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	362,443.3	449,660.5
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	97,810.8	77,970.1
2104	Хангамж, бараа материалын зардал	259,743.4	335,719.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,591.6	106,675.8
2107	Томилолт, зочны зардал	119,676.0	103,077.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,914.9	230,009.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	343,573.3	380,309.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,987.0	74,782.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	118,080.1	1,492,269.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	651.4	11,941.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(V)	117,428.7	1,480,328.8

2.3. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023.12.31-нээрх үлдэгдэл	1,941,120.6		1,941,120.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,941,120.6		1,941,120.6
9	Тайлант үеийн үр дүн	117,428.7		117,428.7
10	2024.12.31-нээрх үлдэгдэл	2,058,549.3		2,058,549.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,058,549.3		2,058,549.3
19	Тайлант үеийн үр дүн	1,480,328.8		1,480,328.8
20	2025.12.31 үлдэгдэл	3,538,878.1		3,538,878.1

2.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,862,090.3	5,334,121.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,334,121.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,862,090.3	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,538,923.3	5,015,471.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,538,923.3	5,015,471.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,139,936.3	4,934,995.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,913,799.5	3,630,312.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	362,237.9	445,122.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,453.8	77,776.9
2104	Хангамж, бараа материалын зардал	270,537.0	246,876.1
2105	Нормативд зардал	9,875.1	2,976.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,638.9	212,020.1
2107	Томилолт, зочны зардал	119,176.0	102,477.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,035.9	143,633.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,182.1	73,800.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,987.0	80,476.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	323,167.0	318,649.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	323,167.0	318,649.9
VI	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	323,167.0	318,649.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(323,167.0)	(318,649.9)
VI	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,749,797,000.00	5,271,021,411.23	478,775,588.77	91.67
12	Татварын бус орлого	5,749,797,000.00	5,271,021,411.23	478,775,588.77	91.67
122	Тусламжийн орлого	5,749,797,000.00	5,271,021,411.23	478,775,588.77	91.67
122005	Төсвөөс санхүүжих	5,749,797,000.00	5,271,021,411.23	478,775,588.77	91.67
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,749,797,000.00	5,271,021,411.23	478,775,588.77	91.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,449,797,000.00	4,971,021,411.23	478,775,588.77	91.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,379,097,000.00	4,953,644,891.23	425,452,108.77	92.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,718,011,100.00	3,630,312,250.51	87,698,849.49	97.64
210101	Үндсэн цалин	1,826,125,900.00	1,796,337,309.81	29,788,590.19	98.37
210102	Нэмэгдэл	1,229,615,500.00	1,152,988,373.68	76,627,126.32	93.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	341,458,700.00	374,664,640.34	(33,205,940.34)	109.72
210104	Урамшуулал	320,811,000.00	306,321,926.68	14,489,073.32	95.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	445,138,100.00	445,122,805.04	15,294.96	100.00
210201	Тэтгэврийн даатгал	302,697,400.00	302,697,400.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	35,628,600.00	35,628,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,839,000.00	17,823,705.04	15,294.96	99.91
210204	Ажилгүйдлийн даатгал	17,794,700.00	17,794,700.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	71,178,400.00	71,178,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,600,000.00	77,776,862.02	12,823,137.98	85.85
210302	Түлш, халаалт	14,600,000.00	12,551,637.55	2,048,362.45	85.97
210304	Байрны түрээс	76,000,000.00	65,225,224.47	10,774,775.53	85.82
2104	Хангамж, бараа материалын зардал	316,842,800.00	246,876,065.16	69,966,734.84	77.92
210401	Бичиг хэрэг	62,351,800.00	40,304,120.00	22,047,680.00	64.64
210402	Тээвэр, шатахуун	83,493,200.00	66,400,000.00	17,093,200.00	79.53
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,897,800.00	40,238,034.36	12,659,765.64	76.07
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,000,000.00	99,833,910.80	18,166,089.20	84.61
2105	нормативд зардал	6,890,000.00	2,976,000.00	3,914,000.00	43.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,890,000.00	2,976,000.00	3,914,000.00	43.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	319,534,300.00	230,670,033.00	88,864,267.00	72.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,100,000.00	18,659,900.00	39,440,100.00	32.12
210604	Урсгал засвар	261,434,300.00	212,010,133.00	49,424,167.00	81.09
2107	Томилолт, зочны зардал	126,000,000.00	102,477,080.00	23,522,920.00	81.33
210702	Дотоод албан томилолт	126,000,000.00	102,477,080.00	23,522,920.00	81.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,780,500.00	143,633,555.30	107,146,944.70	57.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,413,800.00	80,099,750.00	39,314,050.00	67.08
210803	Даатгалын үйлчилгээ	55,068,300.00	1,026,432.00	54,041,868.00	1.86
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,168,700.00	4,118,373.30	50,326.70	98.79
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	300,000.00	264,000.00	36,000.00	88.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	71,829,700.00	58,125,000.00	13,704,700.00	80.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,300,200.00	73,800,240.20	31,499,959.80	70.09

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,300,200.00	73,800,240.20	31,499,959.80	70.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,700,000.00	17,376,520.00	53,323,480.00	24.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,700,000.00	17,376,520.00	53,323,480.00	24.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	300,000,000.00	300,000,000.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛТНЫ ТОО	50	50	-	100.00
620001	Удирдах ажилтан	13	13	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	19	19	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	50	50	-	100.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	19	19	-	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21	21	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	-	100.00
650012	Шүүгч, прокурор	4	4	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Шүүхийн сахилгын хороо нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага юм.

Шүүхийн сахилгын хорооны эрхэм зорилгыг “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулах, шүүгчийн ёс зүй, сахилгын зөрчил, түүнд тохирох хариуцлагыг шударгаар оногдуулах зарчмыг баримтлан ажиллах” гэж тодорхойлжээ.

Шүүхийн сахилгын хороо 2021 онд байгуулагдсанаас хойших хугацаанд шүүгчийн сахилгын зөрчилтэй холбогдуулан хувь хүн, албан тушаалтан, хуулийн этгээдээс ирүүлсэн 1596 өргөдөл, мэдээллийг хянан шийдвэрлэж 49 шүүгчид 65 сахилгын шийтгэл оногдуулсан байна.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Шүүхийн сахилгын хороо Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд хорооны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Шүүхийн тухай хуульд 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр нэмэлт, өөрчлөлтөөр 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн "Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэснийг хассан байна.

Дотоод үйл ажиллагаанд мөрддөг дараах журмыг шинэчлэн баталсан байна. Үүнд:

- "Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам", "Шүүхийн сахилгын хорооны статистикийн мэдээлэл, тайлан гаргах маягтын загвар" батлагдсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны 16 дугаар тушаалаар Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх

хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтийг тусгасан, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,633.2 сая төгрөгөөр буюу 78.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,864.3	-	(2,864.3)
Урьдчилгаа	716,693.1	20,868.2	(695,824.9)
Бараа материал	154,567.0	118,758.3	(35,808.7)
Үндсэн хөрөнгө	1,195,074.9	3,562,848.6	2,367,773.7
Нийт хөрөнгө	2,069,199.3	3,702,475.1	1,633,275.8
Өр төлбөр	10,650.0	163,597.1	152,947.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,058,549.3	3,538,878.0	1,480,328.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,069,199.3	3,702,475.1	1,633,275.8

Эх сурвалж: Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны эхний үлдэгдэлд байсан 2.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бүрэн барагдсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл нь тайлант онд 183.4 сая төгрөг нэмэгдэж, 879.2 сая төгрөг хасагдаж, 20.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 97.1 хувиар буурсан нь 790.1 сая төгрөгийн засварын зардлыг капиталжуулж үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 35.8 сая төгрөгөөр буюу 23.1 хувиар буурсан нь тайлант онд 288.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 323.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 2,367.7 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- ЗГ-ын 2025 оны .12.10-ны өдрийн 188 дугаар тогтоолын дагуу 1,390.2 сая төгрөгийн балансын үнэтэй барилга байгууламж, 9.8 сая төгрөгийн газрын эрхийг Улсын дээд шүүхээс шилжүүлэн авсан. Урьдчилж төлсөн зардлын данснаас нийт 790.1 сая төгрөгийн барилгын сайжруулалтыг үндсэн хөрөнгийн барилга, байгууламжийн дансанд бүртгэсэн.
- Тайлант хугацаанд 12.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 25.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 37.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.
- Худалдан авах төлөвлөгөөний дагуу 220.0 сая төгрөгийн үнэтэй Ланд 300 автомашин 1, 40.0 сая төгрөгийн үнэлгээтэй нийт 80.0 сая төгрөгийн Соната маркийн 2 автомашин тус тус тендер зарлаж худалдан авсан.
- ТӨБЗГ-ын 2025 оны 384 дүгээр тогтоолын дагуу 461-р хорих ангиас 216.6 сая төгрөгийн балансын үнэтэй "Киа Карнивал" автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан.
- ТӨБЗГ-ын 2025 оны 551 дүгээр тогтоолын дагуу 2 нэрийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8.0 сая төгрөгийн балансын үнэтэй тээврийн хэрэгслийг данснаас хасаж, дахин 3.0 сая төгрөгөөр үнэлэн, балансаас балансад шилжүүлсэн.
- ТӨБЗГ-ын 2025 оны 545 дугаар тогтоолын дагуу 34 нэрийн нийт 206.5 сая төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлэхээр данснаас хасаж, 11 нэрийн 2.0 сая төгрөгийн тавилга эд хогшлыг 1.5 сая төгрөгөөр, 23 нэрийн 204.5 сая төгрөгийн тоног

төхөөрөмжийг 123.5 сая төгрөгөөр нийт 125.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн.

- ТӨБЗГ-ын 2025 оны 576 дугаар тогтоолын дагуу 26 нэрийн 16.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 10 нэрийн 107.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 36 нэрийн 124.5 сая төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй, ашиглалтын шаардлага хангахгүй үндсэн хөрөнгийг акталсан.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 152.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ХХОАТ 16.1 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 147.5 сая төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оноос Монгол Улсын Их Сургуульд өгөх 7.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, Ворд медиа ХХК-д 3.1 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна. Энэ нь сангийн яамнаас 2025 оны 4 дүгээр улиралд санхүүжилт буцаан татан төвлөрүүлсэнтэй холбоотой дээрх өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 1,480.3 сая төгрөгийн тайлант оны үр дүнгээр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн 6,481.3 сая төгрөгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр тооцон төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/53 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийг 6,171.9 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны экспортын орлого тасалдсантай холбоотойгоор төсвийн тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн өөрчлөлт оруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах нийт зардлыг 422.1 сая төгрөгөөр бууруулж 5,749.8 сая төгрөгөөр баталсан байна

Тус тодотголоор дараах зардлыг 422.1 сая төгрөгөөр бууруулан тодотгосон. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 86.9 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 23.4 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.5 сая төгрөг;
- Хангамж бараа материалын зардлыг 0.9 сая төгрөг;
- Нормативд зардлыг 0.08 сая төгрөг;
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 87.0 сая төгрөг;
- Томилот, зочны зардлыг 0.2 сая төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 84.1 сая төгрөг;
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 51.0 сая төгрөг;
- Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 1.2 сая төгрөг;
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 86.8 сая төгрөг;

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 4 арга хэмжээг улсын төсвийн 5,749.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,749.8 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт зардлын гүйцэтгэл 5,271.0 сая төгрөг буюу 91.6 хувь байна. Төсвийн 478.8 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний үзүүлэлт

/сая төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
70714	Шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэх	5,749.8	5,271.0	478.8	91.67
80101	Үндсэн үйл ажиллагаа	5,259.6	4,873.6	386.1	92.7
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	119.4	80.1	39.3	67.08
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	70.7	17.3	53.3	24.58
80918	Бусад	300.0	300.0	-	100.00

Эх сурвалж: Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлын 77.3 хувийг албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 1.5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 5.9 хувийг хангамж, бараа материалын зардалд, 4.4 хувийг эд хогшил, урсгал зардалд, 1.9 хувийг дотоод албан томилолтын зардалд, 2.7 хувийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд, 1.4 хувийг бараа үйлчилгээний зардалд, 6.0 хувийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.4. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шүүхийн сахилгын хорооны (ШСХ) даргын 2025 оны 01 дүгэр сарын 08-ны өдрийн 02 дугаар тушаалаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд тус төлөвлөгөөнд 300.0 сая төгрөгийн өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 133.5 сая төгрөгийн өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 846.8 сая төгрөгийн өртөгтэй 31 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар, нийт 1,280.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл арга, хэмжээг урсгал төсвөөр худалдан авахаар төлөвлөсөн байна.

ШСХ даргын 2025 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 15 дугаар тушаалаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталсан бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 300.0 сая төгрөг, харьцуулалтын аргаар 133.5 сая төгрөг, гэрээ шууд байгуулах аргаар 593.7 сая төгрөг, нийт 35 төсөл, арга хэмжээнд 1,027.2 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төсвийг 253.1 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 563.3 сая төгрөг буюу 55 хувьтай байна.

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 300.0 сая төгрөгийн 2,
- Харьцуулалтын аргаар 127.5 сая төгрөгийн 2,
- Шууд худалдан авалтын аргаар 135.8 сая төгрөгийн 31 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх гэрээ байгуулж, 478.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 84.6 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Дээрх өр төлбөр нь 2025 оны 4 дүгээр улиралд Сангийн яамнаас санхүүжилтийг царцааж, төсвийг татсанаас үүссэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Үнэлгээний хороог байгуулж tender.gov.mn цахим системд нээлттэй зарлаж, үнийн саналыг цахимаар авч, хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

3.5.5. Судалгааны үр дүн

Орон тооны судалгаагаар 2025 оны баталсан орон тоог 9 хувиар цомхотгож 50 орон тоотой ажилласан. Цалингийн зардлыг анх 3,818.3 сая төгрөгөөр баталсан бол тодотголоор 100.3 сая төгрөг бууруулан 3,718.0 сая төгрөгөөр баталж, 3,630.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Ажлын албаны даргын 2024 оны А/60 дугаар тушаалаар хоол, унааны хөнгөлөлтийг баталсан. /Хоол хоногийн 32,000.00 төгрөг, унаа 3,000.00 төгрөг/

Гадаад томилолтын зардал батлагдаагүй боловч хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны даргын А/75 дугаар тушаалаар Япон улсад туршлага судлах ажлаар явсан 9 гишүүний нислэгийн зардалд 18.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Шүүхийн сахилгын хороо нь Ординат ХХК-аас Unicus санхүүгийн программыг 7.9 сая төгрөгөөр, Ухаалаг оффис ХХК-аас сахилгын хорооны сахилгын хэргийн бүртгэл, хяналтын иж бүрэн систем хөгжүүлэлтийн 9 үйлдлийн системийг 6.3 сая төгрөгөөр тус тус 2022 онд худалдан авч ашиглаж байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 103.0 сая төгрөгөөр 19 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 2 арга хэмжээг 73.8 сая төгрөгөөр зохион байгуулсан байна.

Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой болон хэвлэл мэдээлэлтэй холбоотой гарсан зардал байхгүй.

1. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Шүүхийн сахилгын хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангах, төсөвт зохицуулалт хийхдээ журам зааврыг баримтлах, үйл ажиллагааны орлогыг төлөвлөх, холбогдох журам зааврыг сайжруулах, мөрдөж ажиллах, батлагдсан бүтэц орон тоог бүрдүүлэх, биет бус хөрөнгийн бүртгэл, хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитор Э.Цэлмэгбаяр нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 976 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,746.5 сая төгрөгөөс 1 хувь буюу 47.4 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин хянаж, тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,402.9 сая төгрөгийн 1 хувиар буюу 54.0 сая төгрөгөөр тогтоож, шинэчлэн тогтоосон.

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж заасны дагуу тайлант оны 2 болон 3 дугаар улирлаас эхлэн хорооны гишүүд, ажлын албаны албан хаагчдын цалин хөлс, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцож, Монгол Улсын засгийн газраас гаргасан чиглэлийн дагуу орон тоог 9 хувиар цомхотгон, 5 орон тоог бууруулснаас цалингийн санг 87.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Бусад зардлын хувьд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 70.0 сая төгрөгөөр, норматив зардлыг 3.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 88.9 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 23.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 107.1 сая төгрөгөөр Бараа үйлчилгээний бусад зардлыг 31.5 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 53.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, нийт 478.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Монгол улсын ерөнхий сайдын 2025 оны 05 албан даалгаврыг зөрчиж 9.7 сая төгрөгийн шаардлагагүй бараа материал бэлтгэсэн, сургалт зохион байгуулахтай холбоотой танхим түрээс, катеринг, тоног төхөөрөмжийн зардалд 11.8

сая төгрөг, Үндэсний их баяр наадмын зогсоолын төлбөр төлөхөд 1.8 сая төгрөг, нийт 23.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар зөрчил илрээгүй.

4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1. Завсрын аудитын талаар

Шүүхийн сахилгын хорооны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 10.2 сая төгрөгийн санхүүгийн 3 зөвлөмж, нийцлийн 5 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага өгсөн нь 97.3 хувийн хэрэгжсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	8	10,189.3	7	3,224.3	87.5
Нийт дүн	9	10,189.3	8	3,224.3	97.3

- Өмнөх оны аудитаар 0.7 сая төгрөгийн төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсантай холбоотой зөвлөмж өгсөн ч тайлант хугацаанд дээрх зөрчил давтан гарсан тул өмнөх аудитын шийдвэрийг хааж, дараагийн шатны шийдэл гарган албан шаардлага өгсөн.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад анхааран үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 52.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 33.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 18.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 52.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

5.1. Төлбөрийн акт

Илрүүлэлт: Албан хаагчдад олгосон томилолтын урьдчилгааг анхан шатны баримттай тулган шалгахад Сангийн сайдын А/52 дугаар тушаалаар тогтоосон хэмжээнээс илүү тооцсон, урьдчилгаа тооцоог томилолтын хуудсанд үндэслэн тухай бүр тооцоо бодоогүйгээс 1.0 сая төгрөгийн томилолтын зардал илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2. Албан шаардлага

Илрүүлэлт 1: Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж 9,710.7 мянган төгрөгийн шаардлагагүй бараа материал бэлтгэсэн, сургалт зохион байгуулахтай холбоотой танхим түрээс, катеринг, тоног төхөөрөмжийн зардалд 11,876.0 мянган төгрөг, Үндэсний их баяр наадмын зогсоолын төлбөр төлөхөд 1,800.0 мянган төгрөг, нийт 23,386.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн" 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;", 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, зориулалт бус зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Ард даатгал ХХК-тай байгуулсан эрүүл мэндийн даатгал, төрөөс иргэн бүрийг эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулах зардлыг олгож байгаатай давхардуулан 10 албан хаагч 9.8 сая төгрөгийн үзлэг шинжилгээг Таван богд Нура ХХК-д хийлгэж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлж төсвийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн" 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хуулийн 4

дүгээр зүйлийн 4.2.3-д "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх;" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3. Зөвлөмж

Илрүүлэлт: Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны даргын А/75 дугаар тушаалаар Япон улсад туршлага судлах ажлаар явсан 9 гишүүний нислэгийн зардалд 18.2 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас эдийн засгийн ангилал зөрүүлж зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн" 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, журмын хэрэгжилтийг хангаж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Албан хаагчдад олгосон томилолтын урьдчилгааг анхан шатны баримттай тулган шалгахад Сангийн сайдын А/52 дугаар тушаалаар тогтоосон хэмжээнээс илүү тооцсон, урьдчилгаа тооцоог томилолтын хуудсанд үндэслэн тухай бүр тооцоо бодоогүйгээс 1,020.0 мянган төгрөгийн томилолтын зардал илүү олгосон.	1	1,020.0	1	1,020.0	-	-	-	-	-	-	-	-
2	ШСХ нь төрийн хэмнэлтийн хууль зөрчиж 9,710.7 мянган төгрөгийн шаардлагагүй бараа материал бэлтгэсэн, сургалт зохион байгуулахтай холбоотой танхим түрээс, катеринг, тоног төхөөрөмжийн зардалд 11,876.0 мянган төгрөг, Үндэсний их баяр наадмын зогсоолын төлбөр төлөхөд 1,800.0 мянган төгрөг, нийт 23,386.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	23,386.7	-	-	1	23,386.7	-	-	-	-	-	-
3	Тус байгууллага нь ард даатгал ХХК-тай 2024 онд эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулж, нэг албан хаагчид үзүүлэх эрүүл мэндийн даатгалын үнэлгээг 20,000.0 мянган төгрөг, гэнэтийн ослын даатгалын үнэлгээг 30,000.0 мянган төгрөгөөр тус тус тогтоон, нийт 45 албан хаагчийн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг 2,250,900.0 мянган төгрөгөөр тохиролцож, 23,912.1 мянган төгрөгийн даатгалын хураамж төлсөн байна. Үүнээс 9 албан хаагчийн эрүүл мэндийн даатгалын нэгж үнэлгээг 50,000.0 мянган төгрөг, гэнэтийн ослын даатгалын үнэлгээг 80,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 1,170,000.0 мянган төгрөгөөр үнэлэн, 13,680.0 мянган төгрөгийн хураамж төлснөөр нийт 37,592.1 мянган төгрөгийн даатгалын хураамжийг Ард даатгал ХХК-д шилжүүлжээ. Уг гэрээгээр эрүүл мэндийн даатгалаас 90 хувь, гэнэтийн ослын даатгалаас 100 хувийн нөхөн олговор олгохоор тусгасан байна. Гэвч тус 9 албан хаагч /гишүүн/ болон Ажлын албаны дарга нь даатгалын нөхөн олговор авах боломжтой урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багц шинжилгээнд хамрагдахын оронд төсвийн мөнгөөр Таван богд Нура ХХК-д нийт 9,800.0 мянган төгрөгийн төлбөртэйгээр шинжилгээ хийлгэсэн нь төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үрэлгэн, давхардуулан зарцуулж, хэмнэлтийн горим баримтлан ажиллаагүй байна.	1	9,800.0	-	-	1	9,800.0	-	-	-	-	-	-
4	Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны даргын А/75 дугаар тушаалаар Япон улсад туршлага судлах ажлаар явсан 9 гишүүний нислэгийн зардалд 18,275.4 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас эдийн засгийн ангилал зөрүүлж зарцуулсан байна.	1	18,275.4	-	-	-	-	1	18,275.4	-	-	-	-
Дүн		4	52,482.2	1	1,020.0	2	33,186.8	1	18,275.4	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 230/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/30/НА - СТА - ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 1,020,000.00 (нэг сая хорин мянга) төгрөгийн албан томилолтыг илүү олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 1,020,000.00 (нэг сая хорин мянган) төгрөгийн албан томилолтын гүйлгээг хянасан Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга (Д.Мөнхзориг), ерөнхий нягтлан бодогч (Б.Ариунжаргал) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



СМ

С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1306/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/30/НА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ард даатгал ХХК-тай байгуулсан эрүүл мэндийн даатгал, төрөөс иргэн бүрийг эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулах зардлыг олгож байгаатай давхардуулан 10 албан хаагч 9,800,000.00 (есөн сая найман зуун мянга) төгрөгийн үзлэг шинжилгээ, Таван богд Нура ХХК-д хийлгэж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлж, төсвийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн" 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх," гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга (Д.Мөнхзориг), ерөнхий нягтлан бодогч (Б.Ариунжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага туйруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264 30

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-14.Docx

1526182087



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1307/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/30/КА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн сахилгын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин байрны тохижилттой холбоотой соёмбо, фемида, медалион, жааз, сувинер, аяны хэрэгсэл гэх мэт зардалд нийт 9,710,700.00 (есөн сая долоон зуун арван мянга долоон зуу) төгрөг, сургалт зохион байгуулахтай холбоотой танхим тоног төхөөрөмж түрээс, катерингийн зардалд нийт 11,876,000.00 (арван нэгэн сая найман зуун далан зургаа) төгрөг, Үндэсний их баяр наадмын зогсоолын төлбөрт 1,800,000.00 (нэг сая найман зуун мянга) төгрөг, нийт 23,386,700.00 (хорин гурван сая гурван зуун наян зургаан мянга долоон зуу) төгрөгийн зардлыг хэмнэлтийн горим баримтлалгүй, зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн" 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилддаггүй, зориулалт бус зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга (Д.Мөнхзориг), ерөнхий нягтлан бодогч (Б.Ариунжаргал) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СМ  О.МАГНАЙСҮРЭН